

**ӨНДӨРХААН ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 4 сарын 27 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Хурал 2020 оны 04 сарын 27 –ний өдрийн 10:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, 5/3 тоот Оффисын хоёрдугаар давхарын хурлын танхимд болов.

Хуралд оролцсон:

1. Г.Хатанболд /Хурлын дарга/
2. Л.Золбаяр /Хувьцаа эзэмшигч/
3. Н.Төгөлдөр /Тооллогын комиссын дарга/

Хурлын ирц:

Өндөрхаан ХК –ийн нийт гаргасан 111,879 ширхэг хувьцаа байгаагаас 111,879 ширхэг саналын эрхтэй хувьцаатай бөгөөд хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр буюу 2020 оны 04 сарын 7 –ны өдрийн байдлаар нийт 303 хувьцаа эзэмшигч байна. Үүнээс 91,313 ширхэг хувьцаатай 1 хувьцаа эзэмшигч буюу 81.62 хувийн ирцтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх хуралд ирсэн тул хурал хүчин төгөлдөрт тооцогдов. Оролцсон хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчийн овог нэр	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшил хувь
1	Лхагвын Золбаяр	91,313	81.62%
Нийт		91,443	81.62%

Хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 03 –р сарын 18 –ний өдрийн 2 тоот тогтоол болон хурлын дэгийн дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

Хэлэлцэх асуудал 1: Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг хэлэлцэх тухай.

Г.Хатанболд:

Өндөрхаан ХК нь Санхүүгийн тайлангийн хувьд 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар Нийт хөрөнгө 34,384.8 мянган төгрөг, Нийт өр 1,130.9 мянган төгрөг, эздийн өмч 33,253.9 мянган төгрөг. 2019 онд үйл ажиллагаа явуулаагүй учраас борлуулалтын орлого болон үйл ажиллагааны зардал гараагүй байна.

Л.Золбаяр: Компанийн нөхцөл байдлыг мэдэж байгаа болохоор үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг батлах саналтай байна.

Шийдвэр 1:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 2: ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай.

Г.Хатанболд: 2020 онд үйл ажиллагаа явуулахгүй учраас ТУЗ-н гишүүдэд цалин урамшуулал олгох боломжгүй байна.

Л.Золбаяр: Компани үйл ажиллагаа явуулж эхлэхээр цалин урамшуулал олгоно гэдэгт итгэж байна. Иймд энэхүү саналыг дэмжиж байна.

Шийдвэр 2:

1. Компани 2020 онд ТУЗ-ийн цалин, урамшуулал олгохгүй байхаар БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 3: ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай.

Г.Хатанболд: ТУЗ-ын гишүүдийг танилцууллаа.

Хараат бус гишүүд:

- Д.Санжид
- Б.Амгаланбаатар
- Э.Пүрэвхам

Ердийн гишүүд:

- Г.Хатанболд
- Н.Улаанхүү
- Л.Золбаяр
- Б.Эрдэнэжаргал
- Д.Баярсайхан
- С.Шагдарсүрэн

Л.Золбаяр: ТУЗ-ын гишүүдийг улируулан сонгохыг дэмжиж байна.

Шийдвэр 3:

1. Компанийн ТУЗ-ийн гишүүд:

Хараат бус гишүүдэд:

- Д.Санжид
- Б.Амгаланбаатар
- Э.Пүрэвхам


Ердийн гишүүн

- Г.Хатанболд

- Н.Улаанхүү
- Л.Золбаяр
- Б.Эрдэнэжаргал
- Д.Баярсайхан
- С.Шагдарсүрэн нарыг улируулан СОНГОСУГАЙ.

Хурлын дарга Г.Хатанболд хуралд оролцогсдод талархал илэрхийлж 11:20 цагт хурал өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:

 Л.ГАНТУЯА

Танилцсан Хурлын дарга:



 Г.ХАТАНБОЛД